

“НОМИНХИШИГ” ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

ТОГТООЛ

2017 оны 07 сарын 26 өдөр

№ 01/103

Баянхонгор сум

“НОМИНХИШИГ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 07 сарын 26-ны өдрийн хурлаас хувьцаа эзэмшигчдийн 2017 оны ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай асуудлыг хэлэлцэн ТОГТООХ нь:

1. “НОМИНХИШИГ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2017 оны 09 сарын 08-ний өдрийн 10 цагт компанийн хурлын зааланд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар доор дурьдсан асуудлуудыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
 - * Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан аудиторын
 - * ТУЗ-ийн болон ХШЗ-ийн тайлан
 - * ТУЗ-ийн гишүүдийг сонгох
 - * ХШЗ-ийн гишүүдийг сонгох
3. Ээлжит бус хуралд санал өгч оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2017 оны 08 сарын 16-ний өдрөөр тогтоосугай.
4. 2016 онд компани алдагдалтай ажилласан тул хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэв.
5. Компанийн ээлжит бус хурал хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан 2017 оны 07 сарын 31-ны өдрийн өдөр тутмын 2-оос доошгүй сонинд зар өгч, энэхүү мэдээллийг хэвлэлд гарсанаас хойш 15 хоногийн дараа давтан зар хүргүүлсүгэй.
6. Компанийн ээлжит бус хурлын мэдэгдэлийг Хавсралт 1, Хурлын дэгийг Хавсралт 2, хувьцаа эзэмшигчдэд хүргэх хурлын материалыг Хавсралт 3, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “саналын хуудас”-ын агуулгыг Хавсралт 4-өөр баталсугай.
7. БДК-аар дамжуулан хуралд санал өгөх хувьцаа эзэмшигчдийн саналыг хурал хуралдахаас 5-аас доошгүй хоногийн өмнө байхаар тогтоосугай.
8. Хурал хуралдуулах ТУЗ-ийн шийдвэр гарсанаас хойш 3 хоногт багтаан “НОМИНХИШИГ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

А.НОМИНХИШИГ